Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Эхний хагас жил | Сүүлийн хагас жил | | |
| 4.4. САЛБАРЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, БОДЛОГО, ХӨТӨЛБӨР, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ, ҮР ДҮНД ҮНЭЛГЭЭ ӨГӨХ, ДОТООД АУДИТ ХИЙХ, ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ СТРАТЕГИЙН ЗОРИЛТ 2.4.7-ИЙН ХҮРЭЭНД: | | | | | | | | |
| 1. | Зорилт 1: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын хууль тогтоомж, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | ҮАЗ | - Бодлогын баримт бичиг;<br>- ХШҮ-ний тайлан; | 0 | 8<br>22 | I-IV улирал | ХШҮДАГ | |
| 1.1 | Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 2 | 2 | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Улсын Их Хурлын Байнгын хорооны тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Засгийн газрын албан даалгаврын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эрхлэх асуудлын 2025 оны I улирлын хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан | 100 |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад 140 шийдвэр, 209 заалтын хүрээнд үүрэг даалгавар өгсөн байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдад үүрэг болгосон хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 209 заалтын хэрэгжилт 2025 оны I улирлын байдлаар 81.7 хувьтай байна. Үнэлгээний дундаж хувийг тооцоход хугацаа болоогүй болон бусад байгууллагын эрхлэх асуудлын хүрээний 26 заалтыг үнэлгээний дундаж хувьд оруулж тооцоогүй болно.<br>2025 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр www.unelgee.gov.mn цахим хуудсанд байршуулан баталгаажуулав.<br>https://new.unelgee.gov.mn/law/<br>- Засгийн газрын тогтоол – 80.6 хувь<br>- Ерөнхий сайдын захирамж - 100.0 хувь<br>- Засгийн газрын хуралдааны тэмдэглэл – 84.5 хувь<br>- Засгийн газрын албан даалгавар – 74.2 хувь<br>2025 оны хэрэгжилтийг эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, үнэлгээний нэгдсэн системд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор байршуулна. 2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ,үнэлгээ хийж байна. | |
| 1.2 | Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 1 | 1 | Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах 59 зорилтын 105 арга хэмжээний хэрэгжилтийг 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар гарган Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллалаа. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар зорилт нь шалгуур үзүүлэлт,зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | зорилтод чиглэсэн арга хэмжээг сайжруулах шаардлагатай буюу 48.6 хувь үнэлэгдлээ. Тайлан, танилцуулгыг удирдлагуудад танилцуулсан.<br>2025 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ,үнэлгээ хийж байна. | |
| 1.3 | Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 1 | 1 | Монгол Улсын Их хурлын 2024 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 35 дугаар тогтоолооор батлагдсан “Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний 1 дүгээр улирлын хэрэгжилтийн тайланг ТЗУГ-аас хүлээн авч, хяналт-шинжилгээ үнэлгээг 3 хавсралт тус бүрээр (Бодлогын тэргүүлэх чиглэл, оны төлөвлөгөө, төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт) хийсэн. Үүнд:<br>1-р хавсралт “Монгол улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл”,<br>2-р хавсралт “Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”,<br>3-р хавсралт “Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний хяналт-шинжилгээ, үнэлгээний үзүүлэлт”<br>“Монгол улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө”-ний 2025 оны 1 дүгээр улирлын хэрэгжилт нь “эрчимжүүлэх шаардлагатай” гэж | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | үнэлэгдсэн. Уг үнэлгээний зөвлөмж, дүгнэлтийг ГБХНХ-ын сайд, ГБХНХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, холбогдох газар нэгжийн дарга нарт хүргүүлэн танилцуулсан. Тус бодлогын баримт бичгийн 2025 оны 2 дугаар улирал буюу эхний хагас жилийн хэрэгжилтийн тайланг Төрийн захиргааны удирдлагын газраас 2025 оны 06 дугаар сарын 13-ны дотор авч, ЗГ-ын 2025 оны 43 дугаар тогтоолын 1-р хавсралтаар батлагдсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын дагуу хяналт-шинжилгээ хийж, тайлан мэдээллийг 2025 оны 07 дугаар сарын 01-ний дотор Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сан (new.unelgee.gov.mn)-д тайлагнаж, газрын даргаар баталгаажуулалт хийлгэхээр ажиллаж байна. | |
| 1.4 | Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 1 | - | Монгол Улсын Их хурлын 2015 оны 53 дугаар тогтоолоор баталсан Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд Монгол Улсын Засгийн газрын 206 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу 2024 | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлогын хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 94 хувьтай үнэлэгдлээ.<br>Тайлан танилцуулгыг удирдлагад танилцуулан ЗГХЭГ-т хүргүүллээ. | |
| 1.5 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 1 | - | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/205 дугаар тушаалаар баталсан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөнд нийт 5 зорилтын 46 арга хэмжээ туссан байна. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2021-2024 оны стратеги төлөвлөгөөний биелэлт 82.0 хувьтай үнэлэгдлээ. | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.6 | Улсын төсөв болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төслүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 3 | - | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт ГБХНХЯ үндсэн хэрэгжүүлэгчээр ажиллаж байгаа дараах 3 төслийн 2024 оны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний тайлан, танилцуулгыг ГБХНХ-ын сайдын 2025 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн 01/677 дугаар албан бичгээр Сангийн сайдад, цахимаар холбогдох газарт тус тус хүргүүлсэн. Үүнд:<br>1. Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл – 2,<br>2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл,<br>3. Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл<br>ХШҮ-ний тайлан, нэгдсэн дүгнэлт, танилцуулгыг Сайд, Төрийн нарийн бичгийн дарга, 3 төслийн захиралд “Танилцуулах хуудас”-аар 2025.02.20-27-ний өдөр танилцуулан ажилласан. | 100 |
| 1.7 | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийнэ | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | - | 1 | Хугацаа болоогүй | - |
| 1.8 | Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдсан төсөл арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | - | 1 | Хугацаа болоогүй | - |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1.9 | Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”-ын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | - | 1 | Хугацаа болоогүй | - |
| 1.10 | Салбарын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 1 | - | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны эдийн засаг, нийгмийн хөгжлийн 19 үзүүлэлт 2024 оны жилийн эцсийн байдлаар 98.4 хувийн биелэлттэй байна.<br>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны эдийн засаг, нийгмийн хөгжлийн 16 үзүүлэлт зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, 3 үзүүлэлт 86.9-98.8 хувийн биелэлттэй байна. | 100 |
| 2. | Зорилт 2: Байгууллагын үйл ажиллагаа, хамтран ажиллах гэрээний гүйцэтгэл, үр дүн, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | ҮАЗ | - Төлөвлөгөө;<br>- ХШҮ-ний тайлан; | 0 | 16<br>60 | I-IV улирал | ХШҮДАГ | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1 | Яамны үйл ажиллагааны хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайлан хүргүүлэх. | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 1 | - | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт хамаарах бодлогын баримт бичиг, холбогдох эрх зүйн акт болон яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, байгууллагын ил тод байдал, Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг баримтлан хян Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны үйл ажиллагааг Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6 дугаар хавсралтын дагуу дүгнэхэд ерөнхий үнэлгээ 94.0 хувь буюу 4.70 оноотой байна. | 100 |
| 2.2 | Яамны нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 9 | 9 | ГБХНХЯ-ны нэгжийн 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн биелэлтэд Монгол Улсын Засгийн газрын 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж | 100 |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>дүгнэх журам"-ын дагуу хяналт, шинжилгээ, үнэлгээ хийлээ.<br>Үнэлгээний дүн
<table>
<tr><th>№</th><th>Нэгж</th><th>хувь</th></tr>
<tr><td>1</td><td>Нэгдсэн бодлого төлөвлөлтийн газар</td><td>93.6</td></tr>
<tr><td>2</td><td>Салбарын хяналтын газар</td><td>91.0</td></tr>
<tr><td>3</td><td>Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар</td><td>92.9</td></tr>
<tr><td>4</td><td>Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газар</td><td>88.8</td></tr>
<tr><td>5</td><td>Цахимжилт, их өгөгдлийн бодлогын газар</td><td>80.0</td></tr>
<tr><td>6</td><td>Хөдөлмөрийн бодлогын газар</td><td></td></tr>
<tr><td>7</td><td>Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газар</td><td>90.0</td></tr>
<tr><td>8</td><td>Төрийн захиргааны удирдлагын газар</td><td></td></tr>
<tr><td>9</td><td>Гэр бүлийн бодлогын газар</td><td></td></tr>
</table></td><td></td></tr>
<tr><td>2.3</td><td>Сайдын тушаал, Сайдын зөвлөлийн хуралдаанаар өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.</td><td>ҮАЗ</td><td>ХШҮ-ний тайлан /тоо/</td><td>0</td><td>1</td><td>1</td><td>Нэг. Сайдын 2024 оны 200 - А тушаал, 30 - Б тушаал, 2 - албан даалгавар зэрэг баримт бичгүүдийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, 2025 оны 02 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд "Танилцуулах хуудас"-аар Сайд, Төрийн нарийн бичгийн дарга, ТЗУГ-ын дарга, ХШҮДАГ-ын дарга нарт танилцуулж, гарын үсгээр баталгаажуулсан. Үүнд:<br>I. А тушаалын биелэлт – 91.9 хувь "бүрэн хэрэгжсэн,<br>II. Б тушаалын биелэлт -100.0</td><td>90</td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хувь “бүрэн хэрэгжсэн,<br>III. Албан даалгаврын биелэлт – 90 хувь “бүрэн хэрэгжсэн”<br>Хоёр. ГБХНХ-ын сайдын 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01 дүгээр албан даалгаврын хэрэгжилтэд 2025.04.01-ний өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үнэлгээний тайлан танилцуулгыг удирдлагад хүргүүлэн танилцуулсан. | |
| 2.4 | Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 1 | 1 | Төрийн нарийн бичгийн даргын тушаалын 2024 оны 01 дүгээр сарын 10-ээс 11 дүгээр сарын 31-ны өдрийг хүртэл гаргасан 313 тушаалын хэрэгжилтийн тайланд Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.<br>Төрийн нарийн бичгийн даргын тушаалын хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 84.7% хувьтай буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” гэж үнэлэгдлээ.<br>2024 оны жилийн эцсийн хэрэгжилтийг авч үзвэл:<br>100 хувьтай -257;<br>90.0 хувьтай -3;<br>70.0 хувьтай -7;<br>50.0 хувьтай 11;<br>30.0 хувьтай 1; | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | ажил зохион байгуулаагүй -0 хувьтай 34 тушаал байна. 2025 оны эхний хагас жилийн гүйцэтгэлд 07 дугаар сарын 01-ний дотор хяналт-шинжилгээ, үнэлгээ хийгдхээр тайлан мэдээг холбогдох газраас авахаар хүлээгдэж байна. | |
| 2.5 | Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 1 | - | Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2024 оны хэрэгжилтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн 2 зорилт, 7 үйл ажиллагаа 2024 оны жилийн эцсийн байдлаар бүрэн хэрэгжсэн буюу 100 хувийн биелэлттэй 6, 90 хувийн биелэлттэй 1 үйл ажиллагаа байна. Нийт үнэлгээгээр Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн зорилт, үйл ажилагааны хэрэгжилт 2024 оны жилийн эцсийн байдлаар 98.6 хувьтай | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байна. | |
| 2.6 | Харьяа агентлаг, төвийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 6 | 6 | Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 43 дугаар тогтоолын 3-р хавсралтаар батлагдсан “Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж, дүгнэх журам”-ын дагуу Салбарын 4 агентлаг, 2 харьяа байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний эхний хагас жилийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн тайлан, танилцуулгыг бэлтгэн Төрийн захиргааны удирдлагын газарт хүргүүлэхээр ажиллаж байна. | 70 |
| 2.7 | Яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ | ҮАЗ | ХШҮ-ний тайлан /тоо/ | 0 | 1 | 1 | ГБХНХЯамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгч ажиллалаа.<br>Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд бодлогын баримт бичигт тусгагдсан, хуулиар олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах 3 зорилтын нийт 155 арга хэмжээ туссан байна.<br>Үүнээс:<br>- Бүрэн хэрэгжсэн 100 хувьтай | 100 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | 117 арга хэмжээ,<br>- 90 хувьтай 24 арга хэмжээ,<br>- 70 хувьтай 9 арга хэмжээ,<br>- 50 хувьтай 1 арга хэмжээ,<br>- 30 хувьтай 3 арга хэмжээ,<br>- УИХ-ын ээлжилт сонгуультай холбоотойгоор 1 арга хэмжээний хэрэгжих хугацаа хойшлогдсон байна.<br>Үнэлгээний дундаж хувийг тооцохдоо хойшлогдсон арга хэмжээг оруулан тооцоогүй болно. Яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт 95.0 хувьтай үнэлэгдлээ. | |
| 3. | Зорилт 3: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, эрсдэлийг тодорхойлж, санхүүгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх. | ҮАЗ | Акт, албан шаардлага, зөвлөмж /тоо/ | 450 | 405 | I-IV Улирал | ХШҮДАГ | |
| 3.1 | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулж ажиллана. | ҮАЗ | Хуулийн хэрэгжилт /хувь/ | 0 | - | 90 хувь | 1. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төв болон харьяа газар, хэлтсүүд, мөн “Хөгжлийн бэрхшээлтэй | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл", "Цар тахлын үед хариу арга хэмжээ авах нийгмийн хамгааллын төсөл", "Онцгой байдлын үеийн дэмжлэг болон хөдөлмөр эрхлэлтийн төсөл"-ийн нэгжийн нийт 214 шилэн дансны 2024 оны болон 2025 оны 01 дүгээр улирлын /www.shilendans.gov.mn/ цахим хуудасны хөтлөлт, нэгдсэн системд мэдээлэл байршуулсан байдал, тайлагналт зэрэгт эхний хагас жилд 2 удаа дотоод хяналт хийж гүйцэтгэсэн.<br>2. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын 2024 оны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн, хавсралт хүснэгтийн хамт 2025 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 09/264 дүгээр, 2025 оны 1 дүгээр улирлын тайланг нэгтгэн, хавсралт хүснэгтийн хамт 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдрийн 09/1326 дугаар албан бичгээр Сангийн яаманд тус тус хүргүүлж, хууль, журмын хэрэгжилтийг хангаж ажилласан.<br>Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, зөрчил дутагдлыг бууруулах, таслан зогсоох ажлын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” 03 дугаар албан даалгаврыг харьяа байгууллагуудад 2025.02.27-ны өдрийн 09/676 дугаар албан бичгээр, яамны Төрийн захиргааны удирдлагын газар, Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газарт 2025.02.27-ны өдөр “Дотоод албан бичиг”-ээр тус тус хүргүүлсэн.<br>Мөн ГБХНХЯ, ҮАГ-ын газартай хамтран 2025.05.13-ны өдөр яамны 10 давхрын хурдын зааланд зохион байгуулсан “ГБХНХ-ын салбарын байгууллагууд, төсвийн ерөнхийлөн захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудит, цаашид анхаарах асуудал” сэдэвт сургалтад оролцож “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, цаашид анхаарах асуудал” сэдвээр сургалт зохион байгуулсан. Сургалтад танхимаар 19 байгууллагын 71, цахимаар 97 байгууллагын 442, нийт 116 байгууллагын 513 удирдах болон санхүүгийн ажилтнууд хамрагдсан. | |
| 3.2 | Төсөвт байгууллага, тусгай сангуудын үйл ажиллагаа, төсвийн хөрөнгийн зарцуулалт, холбогдох хууль журмын хэрэгжилтэд дотоод аудит хийнэ. | ҮАЗ | Аудитын төлөвлөгөөний хэрэгжилт /хувь/ | 0 | - | 80 хувь | 1. ГБХНХ-ын сайдын дэргэдэх дотоод аудитын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн №02 дугаар тогтоолоор “Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт | 70 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллага, тусгай сангийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт шалгалт хийх 2025 оны ажлын төлөвлөгөө"-г батлуулсан.<br>2. ГБХНХЯ-ны ТНБД-ын 2025 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн А/79 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу ХЭД сангийн хөтөлбөр, арга хэмжээний гүйцэтгэл, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийх, тандалт судалгаа хийх, эрсдлийг тогтоох ажлыг БЗД-ийн ХХҮХ-ийн хэмжээнд хийж гүйцэтгэсэн.<br>3. ГБХНХ сайдын 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/77 тушаалаар батлагдсан Удирдамжийн дагуу АНҮТ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн.<br>4. ХХХСХТ-ийн ажилтан иргэн С.Алтансувдаас ирүүлсэн өргөдөлд дурдсан асуудлыг шалгахаар Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2025 оны А/10 дугаар тушаалын хавсралтаар баталсан удирдамжийн дагуу хяналт шалгалт хийсэн. Шалгалтаар санхүү, хөрөнгийн ашиглалттай холбоотой / хөрөнгийн ашиглалт-36.6 сая, түрээс-1,238.5 сая ₮ / нийт 1,275.1 сая төгрөгийн зөрчил илрүүлж зөрчлийг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | арилгуулахаар санал зөвлөмж боловсруулан нэгдсэн тайланд тусгасан болно. | |
| 3.3 | Үндэсний аудитын газар, Сангийн яам, дотоод аудит, хяналт шалгалтаар харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавина. | ҮАЗ | Зөвлөмжийн хэрэгжилт /хувь/ | 0 | - | 90 хувь | 1.Үндэсний аудитын газраас Санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжид дурьдсан зөрчлийн нөхцөл шалтгааныг тогтоож, хяналт-шинжилгээ хийж зөрчлийг давтан гаргахгүй ажиллах талаар онцгой анхаарч, төсвийн сахилга хариуцлагыг нэмэгдүүлэн дотоод аудитын хорооны тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллах тухай Дотоод аудитын хорооны №01 дүгээр тогтоолыг 2023 оны 03 дугаар сарын 24 ний өдрийн 09/883 албан бичгээр хүргүүлж хэрэгжилтэд fas.audit.mn системээр хяналт тавьж ажиллаж байна.<br>2.Үндэсний аудитын газраас 2024 оны Санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт, зөвлөмжийн талаарх мэдээлэл, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг харьяа газруудаас ирүүлэх тухай 2025.03.17-ны өдрийн 09/801 албан бичгийг хүргүүлж мэдээллийг авч салбарын хэмжээнд нэгтгэн шинжилгээ хийсэн.<br>3. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Эдийн засаг, санхүү, төсөв, хөрөнгө оруулалтын газраас Үндэсний аудитын газартай хамтран салбарын харьяа | 90 |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлангийн аудит, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгах, давтахгүй байх сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан.<br>Сургалтад салбарын хэмжээний агентлаг, байгууллагын удирдлага, санхүүгийн ажилтнууд оролцож Үндэсний аудитын газар, ГБХНХ яамны Эдийн засаг, санхүү, төсөь, хөрөнгө оруулалтын газар, ХШҮДАГ-ын удирдлага, ажил хариуцсан албан тушаалтнууд мэдээлэл хийж хэлэлцүүлэг зохион байгуулан Төсвийн тухай хуулийн 16.5.5 хэсэгт заасны дагуу "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" талаар мэдээлэл, тусгайлсан үүрэг чиглэл өгч ажилласан.<br>4. Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын эрхлэх асуудлын хүрээний төсөвт байгууллагуудад 2022-2024 онд захиргааны хууль бус шийдвэрийн улмаас ажлаас үндэслэлгүй халагдсаны улмаас шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, төрд учирсан хохирлын мэдээ, судалгааг нэгтгэж Төрийн албаны зөвлөлд 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 01/1804 дугаар албан бичигээр холбогдох хуулийн дагуу төрд учирсан барагдуулах талаар хүсэлт | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | хүргүүлсэн. | |
| | | | | | | | | 92.9 |

***Төлөвлөгөөг үнэлсэн:***

Төрийн нарийн бичгийн дарга
*(албан тушаал)*

*Тэмдэг*

***Төсвийн шууд захирагч***

........................... / Л.Мөнхзул /
*(гарын үсэг)*

...............................
*(огноо)*

***Тайлагнасан:***

Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
*(албан тушаал)*

***Нэгжийн дарга***

........................... / Д.Ренчиндорж /
*(гарын үсэг)*

...............................
*(огноо)*

*Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын*
*даргын 2023 оны 98 дугаар тушаалын*
*8 дугаар хавсралт*

# ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА Д.РЕНЧИНДОРЖИЙН 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН, МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Байгууллагын нэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

Нэгжийн нэр: Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар

**1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ | Гүйцэтгэлийн түвшин | Нийт (70 оноо) |
|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 |
| 1. | Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт | **92.9** | **65.03** |

**2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт**

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Арга хэмжээний биелэлтийн хувь | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|---|
| 1. | Арга хэмжээ 1. Монголын хуульчдын холбоо (Д.Халиуна). Төрийн албаны тухай хууль / (0.5 кр). | 100% | 12 |
| 2. | Арга хэмжээ 2. Монголын хуульчдын холбоо, Хүний эрх зүйтгэх итгэлцлийг хамгаалах зарчим сургалт хамрагдсан (1 кредит) | 100% | 12 |
| 3. | | | |
| **Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний дундаж оноо** | | | 12 |

**3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ**

| Д/д | Үзүүлэлт | Төсвийн шууд захирагчийн өгсөн үнэлгээ (15 хүртэл оноогоор) |
|---|---|---|
| 1. | Хандлага, ёс зүй | 12 |
| 2. | Удирдан зохион байгуулах | 12 |
| 3. | Асуудал шийдвэрлэх | 12 |
| 4. | Манлайлах | 12 |
| 5. | Багаар ажиллах | 12 |
| 6. | Харилцаа | 12 |
| Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан) | | |
| 7. | Мэргэжлийн ур чадвар 1. | 12 |
| 8. | Мэргэжлийн ур чадвар 2. | 12 |
| 9. | Мэргэжлийн ур чадвар 3. | 12 |
| **Хандлага, ёс зүй, ур чадварын дундаж оноо** | | 12 |

**4. Гүйцэтгэлийн үнэлгээ**

| Д/д | Үнэлгээний үзүүлэлт | Үзүүлэлт тус бүрийн оноо |
|---|---|---|
| 1. | Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт)* | **65.03** |
| 2. | Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | *15 хүртэлх оноо*<br>12 |
| 3. | Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ<br>*(Төсвийн шууд захирагчийн үнэлгээ )* | *15 хүртэлх оноо*<br>12 |
| 4. | Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт<br>*(Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)* | *..... оноо* |
| **Нийт оноо =**<br>( Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо ) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо | | 89.03 |

***Үнэлгээ өгсөн:*** ***Төсвийн шууд захирагч***

Төрийн нарийн бичгийн дарга .............................. /Л.Мөнхзул/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

АТА12944 9132155 9024070603

.............................. *(огноо)*

***Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:*** ***Нэгжийн дарга:***

Хяналт-шинжилгээ,үнэлгээ дотоод аудитын газрын дарга .............................. /Д.Ренчиндорж/

*(албан тушаал)* *(гарын үсэг)* *(албан хаагчийн нэр)*

...................... *(огноо)*